

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

БАТЛАВ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИИН БИЧГИЙН
ДАРГА



ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

Тендер
шалгаруулалтын
дугаар:

Эрдэм шинжилгээ, судалгааны ажил

УУХҮЯ/202412024

Улаанбаатар хот
2024 он

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бурийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5. Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6. Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

- 13. Тендерийн иж бүрдэл**
- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
- 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;
- 13.2.8. ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.
- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн жишиг маягтууд**
- 14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.
- 16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**
- 16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадлана. Үүнд:
- 16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.
- 16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.
- 16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл

оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

- 16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

- 17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.
- 17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.
- 17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

- 18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.
- 18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх

	талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	<p>19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.</p> <p>19.2.Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>19.3.Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>19.4.ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.</p>
20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг	<p>20.1.Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.</p> <p>20.2.III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.</p> <p>20.3.Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.</p>
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	<p>21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.</p> <p>21.2.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.</p> <p>21.3.Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.</p> <p>21.4.Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нэхцэлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсэн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.</p> <p>21.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт</p>

ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мэнгэн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мэнгэн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээнээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол

V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох

32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

32.1.2. ТШЗ-ны 21.3-д заасны дагуу санал болгосон

- үнийн хөнгөлөлт тооцох;
- 32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
- 32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрүүлэх;
- 32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцоходоо дараах аргачлалыг баримтална:
- 32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;
- 32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
- 32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
- 32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
- 32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 33. Тендерийг эрэмбэлэх**
- 33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
- 34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад тесэл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

- 34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

- 34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 35.Мэдэгдэл хүргүүлэх** 35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 36.Гүйцэтгэлийн баталгаа** 36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 37.Урьдчилгаа төлбөр** 37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.
- 38.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 38.3. Шалгарсан оролцог ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.
- 38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.
- 39.Тендер шалгаруулалтын гомдол** 39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

ТШЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Эрдэм шинжилгээ, судалгааны ажил
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: УУХҮЯ/202412024
ТШЗ 1.2	<p>Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц № 1: Аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бүс байгуулах, байршил, кластерын зураглал гаргах талаар судалгаа хийж, санал боловсруулах, зөвлөмж гаргах</p> <p>Багц № 2: Аж үйлдвэрийн чиглэлээр УИХ, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд судалгаа, үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах</p>
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсөөв
ТШЗ 2.1	<p>Нийт төсөвт өртөг: 132,736,200.0</p> <p>Багц № 1: “Аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бүс байгуулах, байршил, кластерын зураглал гаргах талаар судалгаа хийж, санал боловсруулах, зөвлөмж гаргах” 70,000,000.0 төгрөг</p> <p>Багц №2: “Аж үйлдвэрийн чиглэлээр УИХ, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд судалгаа, үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах” 62,736,200.0 төгрөг</p>
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: УУХҮЯ-НЫ ТЗҮГ-ЫН Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн Б.Батжаргал</p> <p>Хаяг: Улаанбаатар хот 15170, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2</p> <p>Утасны дугаар: 51-260222</p> <p>Цахим шуудангийн хаяг: batjargal@mmhi.gov.mn</p>
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: Үгүй
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: Зөвшөөрөхгүй

ТШЗ 16.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”.</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендер илгээх мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ээр ирүүлнэ. 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар. 3. Татварын тодорхойлолт /Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тендер нээх өдрийн байдлаар бүрэн төлсөн байна/. 4. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар тодорхойлолт /Өртэй эсэх/. 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын лавлагаа /Өр төлбөртэй эсэх/. - Хэрэв түншлэлээр тендерт оролцож байгаа бол түншлэлийн гишүүн тус бүр дээрх баримт бичгийг ирүүлнэ.
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”.</p> <ol style="list-style-type: none"> 1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь тухайн багцын батлагдсан төсвийн дүнгээс багагүй байх. 2. Өр, төлбөртэй холбогдох шаардлага. - Хэрэв түншлэлээр тендерт оролцож байгаа бол түншлэлийн гишүүн тус бүр дээрх хоёр шаардлагыг хангасан байна.
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. 2021, 2022, 2023 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ. 2. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойши хөдлийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа ирүүлнэ. - Хэрэв түншлэлээр тендерт оролцож байгаа бол түншлэлийн гишүүн тус бүр дээрх хоёр баримт бичгийг ирүүлнэ.
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: Шаардана</p> <p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: Шаардана</p> <p>Оролцогч нь эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай орон зайн төлөвлөлтийн чиглэлээр онол, практикийн өндөр мэдлэг, мэргэшил бүхий дараах мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн багтай байна. Үүнд:</p> <p>Багц 1. Аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшилын бус байгуулах, байршил, кластерын зураглалын судалгаа</p> <ul style="list-style-type: none"> • <u>Судалгааны багийн ахлагч-1</u> <p>Газар зохион байгуулалт, архитектур, хот ба бус нутгийн төлөвлөлт, эдийн засаг, статистик аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, орон зайн төлөвлөлтийн чиглэлээр мэргэшсэн, 10-аас доошгүй жилийн ажлын болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай, төрөл бүрийн мэдээлэл, судалгааг боловсруулах, үр дүнд анализ хийх,</p>

дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлагнах, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.

- Инженер-1

Химийн инженерчлэл, химийн технологи, механик инженер, металл боловсруулах технологи, металл судлал, технологи, металлурги аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, эрдэм шинжилгээ туршилт, судалгаа хийх, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлагнах, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай байх.

- Судлаач-1

Эдийн засаг, бизнесийн удирдлага, менежмент, нийтийн удирдлага, логистик, газар зүй, статистик аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, орон зайн төлөвлөлтийн баримт бичиг боловсруулсан туршлагатай, эрдэм шинжилгээ туршилт, судалгаа хийх, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлагнах, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.

Багц 2. Аж үйлдвэрийн чиглэлээр УИХ, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд судалгаа, үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах

- Судалгааны багийн ахлагч-1

Эрх зүйч, химийн инженерчлэл, химийн технологи, механик инженер, металл боловсруулах технологи, металл судлал, технологи, металлурги аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, аж үйлдвэрийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, 10-аас доошгүй жилийн ажлын болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай, төрөл бүрийн мэдээлэл, судалгааг боловсруулах, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлагнах, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.

- Эрх зүйч-1

Эрх зүйч мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, аж үйлдвэрийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй ажилласан, эрх зүйн судалгааны ажлын үр дүнг төрийн болон хувийн хэвшлийн хэрэгцээнд ашиглуулсан туршлагатай, төрөл бүрийн мэдээлэл, судалгааг боловсруулах, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлагнах, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.


- Судлаач-1

Химийн инженерчлэл, химийн технологи, механик инженер, металл боловсруулах технологи, металл судлал, технологи, металлурги аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, аж үйлдвэрийн салбартаа 10-аас доошгүй жил ажилласан, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг төрийн болон хувийн хэвшлийн хэрэгцээнд ашиглуулсан туршлагатай, аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчны мэдлэгтэй, төрөл бүрийн мэдээлэл, судалгааг боловсруулах, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах,

	<p>баримт бичиг боловсруулж, тайлагнах, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.</p> <p>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардахгүй</p> <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: Шаардана</p> <p>Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 70 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг сүүлийн гурван жилийн хугацаанд нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгэсэн байх.</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Шаардахгүй</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: Шаардана</p> <p>Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлал, үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.</p>
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт 2. Шаардсан хүний нөөцийн мэдээлийг V бүлгийн маягт 7-ын дагуу ирүүлэх 3. Санал болгож буй ажилтны мэдээллийг V бүлгийн маягт 10 -ын дагуу ирүүлэх 4. Санал болгож буй ажилтны дипломын хуулбар 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээллийг V бүлгийн маягт 2 болон 3-ын дагуу ирүүлэх 6. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээллийг V бүлгийн маягт 4 -ийн дагуу ирүүлэх 7. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулгыг V бүлгийн Маягт 5-аар ирүүлнэ. 8. Үйлчилгээ үзүүлэх хуваарийг V бүлгийн Маягт 6-аар ирүүлнэ.
ТШЗ 19.3	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: Шаардахгүй
ТШЗ 21.4	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: Тохируулахгүй тогтмол байна
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: Баталгаа шаардахгүй
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:
ТШЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр

	Цаг: 14 цаг 00 минут
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 30 минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот 15170, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Засгийн газрын II байр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 408 тоот</p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: Үзүй
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 36.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: Үзүй

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА



"АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ СУУРЬШЛЫН
БУС БАЙГУУЛАХ, БАЙРШИЛ, КЛАСТЕРЫН ЗУРАГЛАЛГАРГАХ ТАЛААР
СУДАЛГАА ХИЙЖ, САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ЗӨВЛӨМЖ ГАРГАХ"
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 2 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

№	АГУУЛГА
1.	Зөвлөх үйлчилгээний нэр
2.	Захиалагч газар, хэлтсийн нэр
3.	Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх хугацаа
4.	Зөвлөх үйлчилгээний үндэлгээ /төсөв/
5.	Зөвлөх үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага

1.	Зөвлөх үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага	<p>боловсруулах үйлдвэрлэлд дунд өндөр технологи дөнгөж 5 гаруй хувийг эзэлж байгаа нь чамлалттай үзүүлэлт юм.</p> <p>Уул уурхай, олборлох салбар ДНБ-ний 25 орчим хувийг, боловсруулах үйлдвэрлэл 8 орчим хувийг сүүлийн таван жил тогтмол үйлдвэрлэж байгаа нь Монгол Улсын аж үйлдвэрийн салбар гол төлөв уул уурхайн салбарт төвлөрсөн болохыг нотолж байгаа бөгөөд МҮ-н эдийн засгийн өсөлт оюун ухаан буюу хүний, институтийн хөгжлөөр бус, харин өгөгдсөн нөөц баялаг буюу уул уурхайгаас хэт хамааралтай байна.</p> <p>Мөн дэлхийн эдийн засгийн судалгааны байгууллагаас институц, дэд бүтэц, мэдээллийн технологийн хэрэглээ, макро эдийн засгийн тогтвортой байдал, эрүүл мэнд, ур чадвар, бүтээгдэхүүний зах зээл, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн систем, зах зээлийн хэмжээ, бизнес, инновацийн чадвар зэрэг 12 үзүүлэлтийг харгалzan гаргасан өрсөлдөх чадварын индексээр манай улс дэлхийн 140 орны 102 дугаарт эрэмбэлэгдэж байна¹.</p> <p>Дээрх тоо баримтуудаас нэгтгэн дүгнэвэл эдийн засгийн хүндрэлээс богино хугацаанд гарах, ДНБ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд Монгол улс уул уурхай давамгайлсан эдийн засгийн бүтцээс мэдлэг, технологид түшиглэсэн боловсруулах үйлдвэрийн бүтэц давамгайлсан эдийн засгийн бүтэцүү шилжих, бодит үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих, гадаад дархлаатай, тогтвортой, хэлбэлзэлгүй хүртээмжтэй өсөлттэй, олон тулгуурт эдийн засаг, тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлыг аж үйлдвэржилтийн бодлоготой уялдуулах шаардлага үүсээд байна.</p> <p>Энэхүү шаардлагын хүрээнд Уул уурхайн түүхий эдэд түшиглэсэн хүнд үйлдвэрийг хүн амын нутагшил, суурьшил, байгаль, цаг уурын онцлог, байгалийн бүсчлэл, дэд бүтцийн хөгжил, нөлөөллийн хүрээ, түүхий эдийн нөөц, боловсруулах үйлдвэрийн байршил, зах зээл зэрэг суурь хүчин зүйлүүдийг харгалzan нефть-хими, кокс-хими, металлургийн үйлдвэр бүтцийн сүлжээг байгуулж хөгжүүлэхийг зорин ажиллаж байгаа бөгөөд аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бүс байгуулах, байршил, кластерын зураглал гаргаснаар хийх шаардлага үүсээд байна.</p>
2.	Судалгааны ач холбогдол	<p>Аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бүс байгуулах, байршил, кластерын зураглалыг гаргаснаар аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг тодорхой чиглэл, байршилд зохистой төвлөрүүлэх, аж үйлдвэрийн кластер, үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулж, хөгжүүлэх, эрчим хүчний эх үүсвэр, цахилгаан дамжуулах шугам сүлжээг төлөвлөх, усан хангамжийн цогц бодлого хэрэгжүүлэх, зам, тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээ бий болгох зэрэг дэд бүтцийн байгууламжуудыг нэгдсэн бодлогоор төлөвлөх, байгуулах, хот суурин байгуулах, хүн амын суурьшлын бүсийг тодорхойлох, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжлийн бие даасан байдал, чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг тодорхойлоход шинжлэх ухааны үндэслэлтэй, суурь судалгаа болох ач холбогдолтой юм.</p>

¹ TheGlobalEconomy.com

3.	Судалгааны зорилго	Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бус байгуулах, байршил, кластерын зураглал гаргах
4.	Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ажил	<p>Аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бус байгуулах, байршил, кластерын зураглалын судалгааны хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, бус нутгийн онцлог, хүн амын нутагшил суурьшил, түүхий эдийн нөөц, зах зээл, дэд бүтэц (ус хангамж, эрчим хүч, зам тээвэр) гэх мэт асуудлыг цогцоор нь авч үзэж, аж үйлдвэрийн өндөр хөгжилтэй гадаад улс, орны туршлагыг харгалzan аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалтын: <ul style="list-style-type: none"> a) Байршлын судалгаа, зураглал; b) Суурьшлын бус байгуулах судалгаа, зураглал; c) Кластерын зураглал (эдгээрийг зурагласан кластерийн зураглал). 2. Судалгааны үр дүнгээр төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардлагатай бүрэн мэдээллийг агуулсан эцсийн тайланг захиалагчийн шаардлагад нийцүүлэн боловсруулах; 3. Судалгааны эцсийн тайлангийн төслийг Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлөөр хэлэлцүүлж, урьдчилсан дүгнэлт гаргуулж, УУХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж эцсийн дүгнэлт гаргуулна.
5.	Санал болгож буй судалгааны арга зүй	<p>Өмнө хийгдсэн эрдэм шинжилгээ судалгааны үр дүн, аж үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлсэн гадаад улс орны туршлага, мэдээллийг цуглуулж түүнийг бүтээлчээр ашиглан харьцуулалт, статистик боловсруулалт, загварчлал, дүн шинжилгээ хийх гэх мэт үр дүнд чиглэсэн судалгааны боломжит бүхий л аргуудыг хэрэглэнэ.</p> <p>Судалгааны зорилго, хамрах хүрээг харгалzan үр дүнг илүү тодотгон харуулахад чиглэсэн судалгаа боловсруулах арга зүй, аргачлалыг судлаач өөрөө сонгоно.</p>
6.	Зөвлөх үйлчилгээний ажлын хүрэх үр дүн болон хэрхэн ашиглах талаар төсөөлөл	<p>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах бүрэн мэдээллийг агуулсан “Аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бус байгуулах, байршил, кластерын зураглал”-ын судалгааны тайлан гарсан байна.</p> <p>Аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бус байгуулах, байршил, кластерын зураглалын судалгааны үр дүнг аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг тодорхой чиглэл, байршилд зохистой төвлөрүүлэх, аж үйлдвэрийн кластер, үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулж, хөгжүүлэх, эрчим хүчиний эх үүсвэр, цахилгаан дамжуулах шугам сүлжээг төлөвлөх, усан хангамжийн цогц бодлого хэрэгжүүлэх, зам, тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээ бий болгох зэрэг дэд бүтцийн байгууламжуудыг нэгдсэн бодлогоор төлөвлөх, байгуулах, хот суурин байгуулах, хүн амын суурьшлын бүсийг тодорхойлох, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжлийн бие даасан байдал, чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ашиглана.</p>

7.	Ажил гүйцэтгэх этгээдэд тавигдах шаардлага	<p>Оролцогч нь эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, тухайн ажлыг гүйцэтгэх материаллаг бааз, тоног төхөөрөмжтэй, орон зайн төлөвлөлтийн чиглэлээр онол, практикийн өндөр мэдлэг, мэргэшил бүхий дараах мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн баг байна. Үүнд:</p> <p><u>Судалгааны багийн ахлагч-1</u></p> <p>Газар зохион байгуулалт, архитектур, хот ба бус нутгийн төлөвлөлт, эдийн засаг, статистик аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, орон зайн төлөвлөлтийн чиглэлээр мэргэшсэн, 10-аас доошгүй жилийн ажлын болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай, төрөл бүрийн мэдээлэл, судалгааг боловсруулах, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлagnaх, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.</p> <p><u>Инженер-1</u></p> <p>Химийн инженерчлэл, химийн технологи, механик инженер, металл боловсруулах технологи, металл судлал, технологи, металлурги аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, эрдэм шинжилгээ туршилт, судалгаа хийх, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлagnaх, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай байх.</p> <p><u>Судлаач-1</u></p> <p>Эдийн засаг, бизнесийн удирдлага, менежмент, нийтийн удирдлага, логистик, газар зүй, статистик аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, орон зайн төлөвлөлтийн баримт бичиг боловсруулсан туршлагатай, эрдэм шинжилгээ туршилт, судалгаа хийх, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлagnaх, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.</p> <p>/Тайлбар: Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын цар хүрээ, тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын хэрэгцээ шаардлагад тулгуурлан Эрдэм шинжилгээ, судалгааны мэргэжилтнийг гэрээгээр ажиллуулж болно/</p>
8.	Судалгааны тайлангийн үе шат	<p><u>Эхлэлийн тайлан:</u></p> <p>Гэрээ байгуулснаас хойш 10 хоногийн дотор дараах ажлыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө.</p> <ul style="list-style-type: none"> - Уг тайланд ажлын даалгавар, гэрээний зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хуваарь багтана. <p><u>Дунд хугацааны тайлан:</u></p> <p>Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд танилцуулж, хүлээлгэн өгнө.</p> <ul style="list-style-type: none"> - Дунд хугацааны буюу явцын тайлан нь гэрээнд тусгасан ажлуудын явц, ажил гүйцэтгэхэд гарч байгаа хүндрэл, шийдвэрлэсэн байдал, ажлын зорилтуудыг биелүүлэх үүднээс санал болгох хувилбар зэргийг хамруулах ба 1-3 хуудсанд багтхаар товч тодорхой байдлаар хийгдэнэ. <p><u>Эцсийн тайлан:</u></p> <p>Гэрээ байгуулснаас хойш 60 хоногийн дотор дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Судалгааны үр дүнг нэгтгэсэн эцсийн тайланг Монгол хэл дээр бэлтгэн Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт

		<p>өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөл, УУХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр тус тус хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулан, хангалттай гэсэн үнэлгээтэйгээр дараах хэлбэрээр тус бүр 3 хувь бэлтгэж захиалагчид хүлээлгэн өгнө. Үүнд:</p> <p>a) Хэвлэмэл тайлан /үндсэн тайлан, хавсралт нийлээд 40-оос 50 хуудас/ болон тайлангийн цахим файл /*.doc өргөтгөлтэй/;</p> <p>b) Судалгааны үр дүнгийн бүрэн мэдээллийг агуулсан танилцуулга 10-15 слайд /танилцуулгын *.ppt өргөтгөлтэй файл/.</p>
9.	Судалгааны тайлан, баримт бичгийн эзэмшил	Судалгааны ажил, гүйцэтгэгчийн гаргаж өгсөн мэдээлэл, тайлан, баримт бичиг нь зөвхөн Захиалагчийн өмч байна.

БАТЛАВ.
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С. МАРНАИСҮРЭН

СМ

“АЖ ҮЙЛДВЭРИЙН ЧИГЛЭЛЭЭР МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН
ГАЗРААС ГАРСАН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД
СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, САНАЛ, ДҮГНЭЛТ БОЛОВСРУУЛАХ”
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

№	АГУУЛГА	
1.	Зөвлөх үйлчилгээний нэр	Аж үйлдвэрийн чиглэлээр УИХ, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд судалгаа, үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах
2.	Захиалагч газар, хэлтсийн нэр	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнд үйлдвэрийн бодлогын газар
3.	Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх хугацаа	Нийт хугацаа: 3 сар (90 хоног) Эхлэх: 2024 оны ... дугаар сарын ... өдөр Дуусах: 2024 оны ... дугаар сарын ... өдөр
4.	Зөвлөх үйлчилгээний үнэлгээ /төсөв/	62,736,200 төгрөг
5.	Зөвлөх үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага	Монгол Улсын Хурал, Засгийн газраас аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой төсөл арга хэмжээг Монгол Улсын урт дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлж ирсэн бөгөөд аж үйлдвэрийн салбар дотроо уул уурхайн олборлох үйлдвэр манай улсын эдийн засагт онцгой үүрэг гүйцэтгэж 2023 оны жилийн эцсийн байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 71%, дотоодын нийт бүтээгдэхүүний 27%, төсвийн орлогын 32%, гадаад шууд хөрөнгө оруулалтын 77%, нийт экспортын 92%-ийг бүрдүүлж байна. Экспортын 90 гаруй хувийг бүрдүүлж байгаа уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, баяжмал, цайрын баяжмал, хайлуур жоншны хүдэр, баяжмал, молибдены баяжмал, газрын тос зэрэг технологийн багтаамжгүй, боловсруулаагүй түүхий эд, баяжмал эзэлж байгаа нь улс орны эдийн засгийг хөгжүүлэх ихээхэн боломжийг алдаж байгааг илэрхийлж байна. Түүхий эдийн экспорт давамгайлсан манай улсын хувьд аж үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж экспортын үндсэн түүхий эд болох нүүрс, газрын тос, зэс, төмрийн хүдрийн боловсруулалтын түвшнийг ахиулах замаар, дэвшилтээ техник, технологи, инновацад суурилсан нэмүү өртөг шингэсэн, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлэн эдийн

		засгийн өсөлтийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх нь нэн тэргүүний зорилт болон тавигдаж байна. Дэлхийн эдийн засгийн эерэг шалгуур үзүүлэлтээр боловсруулах үйлдвэрлэлийн тухайн улсын ДНБ-д эзлэх хувь 20% байдаг бол манай улсын боловсруулах салбарын ДНБ-д эзлэх хувь 8-9% байна. Нийт боловсруулах үйлдвэрлэлд дунд өндөр технологи дөнгөж 5 гаруй хувийг эзэлж байгаа нь чамлалттай үзүүлэлт юм. Уул уурхай, олборлох салбар ДНБ-ний 25 орчим хувийг, боловсруулах үйлдвэрлэл 8 орчим хувийг сүүлийн таван жил тогтмол үйлдвэрлэж байгаа нь Монгол Улсын аж үйлдвэрийн салбар гол төлөв уул уурхайн салбарт төвлөрсөн болохыг нотолж байгаа бөгөөд Монгол Улсын эдийн засгийн өсөлт оюун ухаан буюу хүний, институцийн хөгжлөөр бус, харин өгөгдсөн нөөц баялаг буюу уул уурхайгаас хэт хамааралтай байна.
10.	Зөвлөх үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага	Дээрх тоо баримтуудаас нэгтгэн дүгнэвэл эдийн засгийн хүндрэлээс богино хугацаанд гарах, ДНБ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд Монгол улс уул уурхай давамгайлсан эдийн засгийн бүтцээс мэдлэг, технологид түшиглэсэн боловсруулах үйлдвэрийн бүтэц давамгайлсан эдийн засгийн бүтцэд шилжих, бодит үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих, гадаад дархлаатай, тогтвортой, хэлбэлзэлгүй, хүртээмжтэй өсөлттэй, олон тулгуурт эдийн засаг, тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлыг аж үйлдвэржилтийн бодлоготой уялдуулах шаардлага үүсээд байна. Дээрх шаардлагын хүрээнд аж үйлдвэрийн чиглэлээр УИХ, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, чанар үр өгөөж, уялдаа холбоо, давхардал, хийдэл зөрчил, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл, тулгамдаж буй хэрэгцээ шаардлага, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, аж үйлдвэрийг дэмжих хөгжүүлэх шаардлагатай эрх зүйн орчны хэтийн төлөвийг тодорхойлох шаардлага үүсээд байна.
11.	Судалгааны ач холбогдол	Аж үйлдвэрийн чиглэлээр УИХ, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, чанар үр өгөөж, уялдаа холбоо, давхардал, хийдэл зөрчил, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл, тулгамдаж буй хэрэгцээ шаардлага, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, төрөөс аж үйлдвэрийг хөгжүүлэх талаар баримталж байгаа бодлогын хүрээнд шинээр боловсруулж батлуулах шаардлагатай эрх зүйн орчны хэтийн төлөвийг тодорхойлж, аж үйлдвэрийг дэмжих хөгжүүлэх талаар хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг шинэчлэх, шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт хийхэд суурь судалгаа болох ач холбогдолтой юм.
12.	Судалгааны зорилго	Аж үйлдвэрийн чиглэлээр УИХ, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, чанар үр өгөөж, уялдаа холбоо, давхардал, хийдэл зөрчил, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл, тулгамдаж буй хэрэгцээ шаардлага, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, төрөөс аж үйлдвэрийг хөгжүүлэх талаар баримталж байгаа бодлогын хүрээнд шинээр боловсруулж батлуулах шаардлагатай эрх зүйн орчны хэтийн төлөвийг тодорхойлж, аж үйлдвэрийг дэмжих хөгжүүлэх талаар хууль

		тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг шинэчлэх, шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт хийх дүгнэлт, санал боловсруулах.
13.	Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ажил	<p>Аж үйлдвэрийн (уул ўурхайн олборлох, боловсруулах) чиглэлээр УИХ, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд судалгаа, үнэлгээ хийх, санал, дүгнэлт боловсруулах судалгааны хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аж үйлдвэрийн эрх зүйн харилцааг зохицуулах, дэмжкин хөгжүүлэх, чиглэлээр 1990 оноос хойш Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан дараах баримт бичгүүдийн /хүчинтэй болон хүчингүй/ жагсаалт гаргах, судлах. Үүнд: <ol style="list-style-type: none"> a) Монгол Улсын хууль; b) Улсын Их Хурлын тогтоол; c) Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол; d) Ерөнхийлөгчийн зарлиг; e) Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр; f) Засгийн газрын тогтоол; g) Ерөнхий сайдын захирамж; h) Засгийн газрын хуралдааны тэмдэглэл; i) Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар. j) Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого k) Хөгжлийн зорилтот хөтөлбөр l) Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл m) Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл n) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр o) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө p) Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр q) Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө r) Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр s) Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө 2. Дээрх баримт бичгүүдийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, чанар үр өгөөж, уялдаа холбоо, давхардал, хийдэл зөрчил, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл, тулгамдаж буй хэрэгцээ шаардлага, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох асуудлаар дүгнэлт, санал боловсруулна. 3. Аж үйлдвэрийн эрх зүйн зохицуулалтын олон улсын (4-өөс доошгүй гадаад улсын) туршлагыг харгалзан төрөөс аж үйлдвэрийг хөгжүүлэх талаар баримталж байгаа бодлогын хүрээнд шинээр боловсруулж батлуулах шаардлагатай эрх зүйн орчны хэтийн төлөвийг тодорхойлж, аж үйлдвэрийг дэмжих хөгжүүлэх талаар хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг шинэчлэх, шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт хийх дүгнэлт, санал боловсруулна. 4. Судалгааны үр дүн, хууль эрх зүйн чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ бүхий санал, дүгнэлтийг багтаасан тайлангийн төслийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн

		Боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хурлаар хэлэлцүүлж, урьдчилсан дүгнэлт гаргуулж, УУХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж эцсийн дүгнэлт гаргуулна.
14.	Санал болгож буй судалгааны арга зүй	<p>Өмнө хийгдсэн судалгааны үр дүн, өнөөгийн нөхцөл байдал, аж үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлсэн гадаад улс орны туршлага, хууль эрх зүйн байдал, холбогдох мэдээллийг цуглуулж түүнийг бүтээлчээр ашиглан харьцуулалт, статистик боловсруулалт, загварчлал, дүн шинжилгээ хийх гэх мэт /хууль тогтоомжоор зохицуулсан бол тэрхүү арга аргачлалаар/ үр дүнд чиглэгдсэн судалгааны боломжит бүхий л аргуудыг хэрэглэнэ.</p> <p>Судалгааны зорилго, хамрах хүрээг харгалзан үр дүнг илүү тодотгон харуулахад чиглэсэн судалгаа боловсруулах арга зүй, аргачлалыг судлаач өөрөө сонгоно.</p>
15.	Зөвлөх үйлчилгээний ажлын хүрэх үр дүн болон хэрхэн ашиглах талаар төсөөлөл	Судалгааны үр дүнг уул уурхайн гаралтай түүхий эдэд түшиглэсэн боловсруулах үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, урт дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад ашиглана.
16.	Ажил гүйцэтгэх этгээдэд тавигдах шаардлага	<p>Оролцогч нь эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, тухайн ажлыг гүйцэтгэх материаллаг бааз, тоног төхөөрөмжтэй, аж үйлдвэрийн эрх зүйн орчны чиглэлээр онол, практикийн мэдлэг, мэргэшил бүхий дараах мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн багтай байна. Үүнд:</p> <p><u>Судалгааны багийн ахлагч-1</u></p> <p>Эрх зүйч, химийн инженерчлэл, химийн технологи, механик инженер, металл боловсруулах технологи, металл судлал, технологи, металлурги аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, аж үйлдвэрийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, 10-аас доошгүй жилийн ажлын болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай, төрөл бүрийн мэдээлэл, судалгааг боловсруулах, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлагнах, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.</p> <p><u>Эрх зүйч-1</u></p> <p>Эрх зүйч мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, аж үйлдвэрийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй ажилласан, эрх зүйн судалгааны ажлын үр дүнг төрийн болон хувийн хэвшлийн хэрэгцээнд ашиглуулсан туршлагатай, төрөл бүрийн мэдээлэл, судалгааг боловсруулах, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлагнах, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.</p> <p><u>Судлаач-1</u></p> <p>Химийн инженерчлэл, химийн технологи, механик инженер, металл боловсруулах технологи, металл судлал, технологи, металлурги аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, аж үйлдвэрийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан,</p>

		<p>Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг төрийн болон хувийн хэвшлийн хэрэгцээнд ашиглаулсан туршлагатай, аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчны мэдлэгтэй, төрөл бүрийн мэдээлэл, судалгааг боловсруулах, үр дүнд анализ хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж, тайлганах, гадаад хэлнээс материал орчуулан ашиглах мэдлэг, чадвартай байх.</p> <p>Тайлбар: Судалгааны ажлын цар хүрээ, тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын хэрэгцээ шаардлагад тулгуурлан Эрдэм шинжилгээ, судалгааны мэргэжилтнийг гэрээгээр ажиллуулж болно/</p>
17.	Судалгааны тайлангийн үе шат	<p>Эхлэлийн тайлан:</p> <p>Гэрээ байгуулснаас хойш 10 хоногийн дотор дараах ажлыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө.</p> <ul style="list-style-type: none"> - Уг тайланд ажлын даалгавар, гэрээний зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хуваарь багтана. <p>Дунд хугацааны тайлан:</p> <p>Гэрээ байгуулснаас хойш 50 хоногийн дотор дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд танилцуулж, хүлээлгэн өгнө.</p> <ul style="list-style-type: none"> - Дунд хугацааны буюу явцын тайлан нь гэрээнд тусгасан ажлуудын явц, ажил гүйцэтгэхэд гарч байгаа хүндрэл, шийдвэрлэсэн байдал, ажлын зорилтуудыг биелүүлэх үүднээс санал болгох хувилбар зэргийг хамруулах ба 1-3 хуудсанд багтахаар товч тодорхой байдлаар хийгдэнэ. <p>Эцсийн тайлан:</p> <p>Гэрээ байгуулснаас хойш 90 хоногийн дотор дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Судалгааны үр дүнг нэгтгэсэн эцсийн тайланг Монгол хэл дээр бэлтгэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хурлаар хэлэлцүүлж, УУХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр тус тус хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулан, хангалттай гэсэн үнэлгээтэйгээр дараах хэлбэрээр тус бүр 3 хувь бэлтгэж захиалагчид хүлээлгэн өгнө. Үүнд: <ul style="list-style-type: none"> c) Хэвлэмэл тайлан /үндсэн тайлан, хавсралт нийлээд 40-өөс 50 хуудас/ болон тайлангийн цахим файл /*.doc өргөтгөлтэй/; d) Судалгааны үр дүнгийн бүрэн мэдээллийг агуулсан танилцуулга 10-15 слайд /танилцуулгын *.ppt өргөтгөлтэй файл/.
18.	Судалгааны тайлан, баримт бичгийн эзэмшил	Судалгааны ажил, гүйцэтгэгчийн гаргаж өгсөн мэдээлэл, тайлан, баримт бичиг нь зөвхөн Захиалагчийн өмч байна.

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Үйлчилгээ дуусгах хугацаа: *Ашиглана*

Хэрэв “ашиглах” бол: *Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарыт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай*. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарыт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд [хувь бичих]-аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарыт зааснаас [тоо бичих]-аас илүү [“cap”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих] хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: *Ашиглахгүй*

Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: *Ашиглахгүй*

4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: *Ашиглахгүй*

Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. [Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]

Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх тендерийн харьцуулах үнийг тодорхойлж болно.

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ Маягт 1. Тендер илгээх маягт

[огноо]

[Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээнээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.²
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

² Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*

Хаяг:

Маягт 2. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 3.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцгчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

- | | |
|----|--|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) |
| | <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч |

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж ирүүлнэ.

Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

Маягт 7.Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 10. Санал болгож буй ажилтны жишиг намтар (сү)

Санал болгож буй албан тушаал: _____

Овог, нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшил мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшил хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрт онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Маягт 11. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	[“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих]

Маягт 12. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

		Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.			
2.			
3.			
4.			
5.			

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ үзүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохирнуулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;

1. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
2. Гэрээний үнийг тендерийн үнэд запруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
3. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
4. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
5. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
6. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ: ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утyg агуулна:
 - 1.1.1. "Захиалагч" гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. "Захиалагчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. "Гүйцэтгэгч" гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. "Гүйцэтгэгчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. "Талууд" гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. "Хууль" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. "Үйлчилгээ" гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. "Ажлын байр" гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. "Баталгаат хугацаа" гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. "Гомдлын шаардлага гаргах хугацаа" гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. "Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал" гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

- 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
- 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
- 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
- 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

Захиалагчийн үүрэг	нийтлэг	2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө. 2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө. 2.3. Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.
Захиалагчийн төлөөлөгч		2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно. 2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. 2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
Талбайд зөвшөөрөл	нэвтрэх	2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно. 2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

Гүйцэтгэгчийн үүрэг	нийтлэг	3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө. 3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө. 3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизмын сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
---------------------	---------	--

- | | |
|--|---|
| | <p>3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.</p> |
| | <p>Гүйцэтгэгчийн төлөөлөгч</p> <p>3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.</p> <p>3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> |
| | <p>Техникийн болон ажлын талбайн өгөгдөл</p> <p>3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.</p> |
| | <p>Аюулгүй байдал</p> <p>3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.</p> <p>3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.</p> <p>3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нэлөөллөөс хамгаална.</p> <p>3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p> <p>3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.</p> <p>3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.</p> <p>3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.</p> |

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

- | | |
|--|---|
| | <p>Ажил эхлэх</p> <p>4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.</p> <p>4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын</p> |
|--|---|

	үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
Хугацаа сунгах	<p>4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.</p> <p>4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <ul style="list-style-type: none"> 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд Гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон; 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал; 4.5.3. Захиалагч хугацаандaa төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй; 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн. <p>4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.</p> <p>4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.</p> <p>4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.</p> <p>4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.</p>
Ажлын явцын тайлан	ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ
Гэрээний үнэ	<p>5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.</p> <p>5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p>
Урьдчилгаа төлбөр	<p>5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p>

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Гэрээний үнэ	<p>5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.</p> <p>5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p>
Урьдчилгаа төлбөр	<p>5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p>

- Төлбөрийн нөхцөл
- 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнэ.
 - 5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
 - 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
 - 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
 - 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
 - 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сутгана.

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | | |
|------------------------|-----------|--|
| Урьдчилгаа
баталгаа | төлбөрийн | 6.1. ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | | <ol style="list-style-type: none"> 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн З хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. 6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна: <ol style="list-style-type: none"> 6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй; 6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнэ. 6.7. Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана. 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно. |
| Чанарын баталгаа | | |

- 6.9. ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 6.10. Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнэ.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг сутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- | | |
|--------------------------------------|--|
| Бусдад учруулсан
хохирлыг арилгах | 7.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна. |
| Захиалагчийн
эрсдэл | 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй. |
| Даатгал | <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <ol style="list-style-type: none"> 7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан; 7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан; 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан; 7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл. <p>7.4. Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.</p> <p>7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.</p> <p>7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.</p> <p>7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> |

- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

Доголдлыг арилгах	илрүүлэх,	<ol style="list-style-type: none"> 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна. 8.2. Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө. 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ. 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана. 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно. 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө. 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана. 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
Далд доголдол		<ol style="list-style-type: none"> 8.10. Зураг төслийн доголдол арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна. 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.
Захиалагч гэрээг цуцлах		<p>ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ</p> <ol style="list-style-type: none"> 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: <ol style="list-style-type: none"> 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй; 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;

- | | |
|--|--|
| | <p>9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;</p> <p>9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;</p> <p>9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> <p>9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;</p> <p>9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.</p> <p>9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нэхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нэхцөлийг хангахгүй болсон.</p> |
| | <p>9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.</p> <p>9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:</p> |
| | <p>9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;</p> <p>9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> <p>9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сергэөр нөлөөлөхөөр бол.</p> |
| | <p>Гэрээг цуцлах журам</p> <p>9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p> <p>9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нэхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.</p> |

- Гэрээг цуцалсны дараах төлбөр
- 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

Мэдэгдэл

- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огиогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

- | | | |
|---|---------------------------|--|
| <p>Төлөөлөгч өөрчлөгдөх</p> <p>Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл</p> <p>Гэнэтийн давагдашгүй шинжктэй онцгой байдал</p> | <p>буюу хүчний нөхцөл</p> | <p>10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.</p> <p>10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.</p> <p>10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.</p> <p>10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.</p> <p>10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын еренхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.</p> <p>10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.</p> <p>10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.</p> <p>10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжктэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.</p> |
|---|---------------------------|--|

- Оюуны өмчийн эрх зөрчих
- Алданги
- Маргаан шийдвэрлэх
- 10.20. Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
 - 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандaa гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
 - 10.22. Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
 - 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
 - 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
 - 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
 - 10.26. Маргааныг зөвшилцэж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: 2024 оны 06 дугаар сарын 03
ГЕН 4.2.	Үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: 2024 оны 06 дугаар сарын 13
ГЕН 4.9.	Үйлчилгээний тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: Багц-1 2024 оны 08 дугаар сарын 03 Багц-2 2024 оны 09 дүгээр сарын 03
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: Хийхгүй
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: Үгүй
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа:
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа: Гэрээ дүгнэсэн актыг үндэслэн ажлын 5 хоногт багтаан Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа:
ГЕН 6.7.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: Шаардахгүй Чанарын баталгаа шаардах бол, Чанарын баталгааны хэмжээ:
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: Үгүй
ГЕН 7.5.	Даатгал: Үгүй
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: хоног тутамд 0.3 хуевь
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: хоног тутамд 0.3 хуевь

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
 - 3.7. Техникийн тодорхойлолт;
 - 3.8. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнэ. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 04 дүгээр сарын 18**

Тендер шалгаруулалтын төрөл: **Үйлчилгээ**

Тендер шалгаруулалтын нэр: **Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **[УУХҮЯ/202412024]**

Нийт төсөвт өртөг: **132,736,200.0 төг**

Тендер шалгаруулалтын арга: **Нээлттэй**

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **Тийм**

Багц № 1: “Аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурышлын бус байгуулах, байршил, кластерын зураглал гаргах талаар судалгаа хийж, санал боловсруулах, зөвлөмж гаргах”

Багц №2: “Аж үйлдвэрийн чиглэлээр УИХ, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд судалгаа, үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах”

- Тендерийг **2024 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 14 цаг 00 минутаас-аас өмнө** тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 14 цаг 30 минутад** нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **Зөвшөөрөхгүй**
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхгүй**
- Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Үгүй”** Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
- Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Захиалагчийн хаяг, утас/цахим шуудангийн хаяг

Хаяг: Улаанбаатар хот 15170, Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын II байр, баруун жигүүр, Нэгдсэн Үндэсний гудамж 5/2

Утасны дугаар: **51-260222**

Цахим шуудангийн хаяг: www.mmti.gov.mn